

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан .....	5
	2.1. Оршил .....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	9
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл .....	9
	2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	10
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	11
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	11
	2.11. Шилэн дансны мэдээлэл .....	12
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	12
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	13
3	Менежментийн захидал .....	14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	20
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	20
	4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	22
	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	25
	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	28
	4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	29
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	32

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТБОНӨБАУХА тухай хууль	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТБОНӨ тухай хууль	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
АШУҮИС Төв	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төв сургууль
БАС	Био анагаахын сургууль
НЭМС	Нийгмийн эрүүл мэндийн сургууль
НАСС	Нүүр ам судлалын сургууль
АУС	Анагаах ухааны сургууль
МАУОУС	Монголын анагаах ухааны олон улсын сургууль
ТЭШ	Төсөл эрдэм шинжилгээ
ИСНэмнэлэг	Их сургуулийн нэгдсэн эмнэлэг
Дорноговь АУС	Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль
Говь-Алтай АУС	Говь-Алтай дахь салбар Анагаах ухааны сургууль
Дархан-Уул АУС	Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургууль



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  
Ж.ЦОЛМОН ТАНАА

2019.03.27 № 06/611  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт/, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгын үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй, хураангуй бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баримтжуулаагүй, дотооддоо батлан мөрдөж байгаа дүрэм, журмын шаардлага, нөхцөлийг баримтлаагүй, санхүүгийн тайланд хийсэн аудитаар төрийн өмчийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүйгээс 15,544.5 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийн дансны үлдэгдэл батлагдаагүй.

Төв сургуулиас 6 нэр төрлийн тоног төхөөрөмжийн үнэнд 11.9 сая вон буюу 27.9 сая төгрөг, 28 нэр төрлийн оношлуурын үнэнд 17.2 сая вон буюу 39.9 сая төгрөг, бүгд 67.8 сая төгрөгийг Бүгд Найрамдах Солонгос Улсын банкны дансанд шилжүүлж төсөл эрдэм шинжилгээний зардалд бүртгэсэн байна.


Нүүр ам судлалын сургууль 2018 оны эхний 9 сард ажлаас чөлөөлөгдсөн, түр чөлөө авсан 5 ажилтны нэр дээр цалин бодож 10.9 сая төгрөгийг, 55 ажилтны цалингаас 42.9 сая төгрөгийг цалингийн картанд дутуу шилжүүлж, нийт 53.8 сая төгрөгийг нэр бүхий 2 хүний 3 картанд шилжүүлэн мөнгө залилан авсан зэрэг зөрчлүүд нь оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг тус сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Цолмон Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн эд хариуцагчдын тайлан гаргалт, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг сайжруулах, авлага, өр төлбөрийн тооцоо нийлэлтийг тогтмолжуулах, төсөл эрдэм шинжилгээний орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх тухай, бараа материалын зарцуулалтыг тайлагнах, баримтжуулах тухай, батлагдсан зураг төсөв, шийдвэргүйгээр засварын зардал гаргахгүй байх, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, татварын болон нийгмийн даатгалын хуулиудын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх тухай зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 15-наас 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “СМД аудит” ХХК-ийн аудитор Д.Гэндэнпэлжээ ахлагчтай аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль 2018 оны санхүүгийн тайланг “СМД аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 1/336 дугаар албан бичгээр 13 бүрэлдэхүүн сургууль, байгууллагын тайланг ирүүлсэн. 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр үлдсэн 2 бүрэлдэхүүн сургуулийн тайланг хугацаа хоцроон ирүүлж, 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр 1/574 дугаар албан бичгээр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн нэгтгэсэн тайланг тус тус ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт , Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

#### **Эрхэм зорилго:**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь “Олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн, эрдэм шинжилгээ, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг, үндэсний тэргүүлэх, Номхон далайн баруун эргийн бүсийн анагаах ухааны шилдэг 100 их сургуулийн нэг байхад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

#### **Үйл ажиллагааны чиглэл:**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн улсын бүртгэлийн гэрчилгээн дээр тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас олгосон сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн хавсралтад заасан боловсрол олгох үйл ажиллагаа гэж тодорхойлжээ.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг доорх хуулийн хүрээнд эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой зохих хэмжээнд нийцсэн байна.



Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Материаллаг байдлын суурийг тооцохдоо тус сургууль нь өөрийн орлогоор санхүүждэг тул санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 38,837.5 сая төгрөгийн 1 хувь буюу 388.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Эрсдэл их гэж үзсэн учир, материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар сонгох нь зүйтэй гэж үзэв.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### 2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

/сая төгрөгөөр/

Үүнээс: Нягтлан бодох бүртгэлийн залруулгын ангилал					
№	Залруулгын товч утга	Бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой	Тайлант хугацаанд гарсан бүртгэлийн тооцооллын алдаа	Өмнөх тайлант хугацаанд гарсан бүртгэлийн тооцооллын алдаа	Бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой
1	Урьдчилж орсон орлогыг залруулсан			441.4	
2	Хандивын хөрөнгийг орлогоор бүртгүүлсэн			32.8	
	Дүн			474.2	

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/сая төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	8	1,733.8	
2	Төлбөрийн акт тогтоосон	3	128.7	
3	Албан шаардлага өгсөн	2	15,602.7	
	Дүн	13	17,465.2	

### **2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

- АШУҮИС-ийн Төв сургуулиас Био Анагаахын сургуульд 48.3 сая төгрөгийн үнэтэй генийн дэслэгч уншигч машиныг шилжүүлснийг, Био Анагаахын Сургууль үндсэн хөрөнгийг орлогод бүртгээгүй;
- Төсөл эрдэм шинжилгээний санхүүжилтээр 5.0 сая төгрөгийн суурилуулсан тоног төхөөрөмжийг орлогоор бүртгээгүй;
- Нийгмийн эрүүл мэндийн сургууль 4.9 сая төгрөгийн дотор орчны агаарын бохирдолт хэмжигч багажуудыг зардлаар бүртгэн зарлагадсан;
- Тайлант онд үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг баримтжуулаагүй, техник ашиглалтын паспортын хөтлөлт бүрэн биш, тооллого хийж тооцоог баталгаажуулаагүй, өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийн бүртгэлээр тавих хяналт сул зэрэг зөрчлөөс үүдэн машин тоног төхөөрөмжийн үлдэгдэл 15,544.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бодитой оршин байгаа нь нотлогдохгүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн 13.4, 13.5, 13.7-д заасныг тус тус зөрчсөн учир Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүлэх;

#### **2. Төсөл эрдэм шинжилгээний зардалтай холбоотой асуудал**

Төв сургуулийн харилцах данснаас 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр 28 нэр төрлийн оношлуурын төлбөр 17.2 сая вон буюу 39.9 сая төгрөг, 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 6 нэр төрлийн тоног төхөөрөмжийн төлбөр 11.9 сая вон буюу 27.9 сая төгрөг, нийт 67.8 сая төгрөгийг БНСУ-руу шилжүүлж, зардлаар бүртгэсэн байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.7-д заасныг тус тус зөрчсөн учир Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоох;

### **3. Зардлын данстай холбоотой асуудал**

- Эрхэс хэвлэх үйлдвэр нь тайлант хугацаанд хувь хүний дансруу 7.1 сая төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлсэн байна.
- НАСС-ийн 2018 оны эхний 9 сард ажлаас чөлөөлөгдсөн, түр чөлөө авсан 5 ажилтны нэр дээр цалин бодож 10.5 сая төгрөг, 55 ажилтны цалингаас 43.2 сая төгрөгийг цалингийн картанд дутуу шилжүүлж, нийт 53.8 сая төгрөгийг нэр бүхий 2 хүний 3 картанд шилжүүлэн мөнгө залилан авсан байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.13-д заасныг тус тус зөрчсөн учир Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоох, хуулийн байгууллагад шилжүүлэх;

### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дэргэд байгуулагдсан гарааны компаниудын санхүүгийн баримтуудыг аудитын хугацаанд өгөөгүй учир аудитад хамруулаагүй. Төсөл эрдэм шинжилгээ технологийн албаны 2015-2018 онуудад гүйцэтгэсэн төсөл эрдэм шинжилгээний тайлан судалгаанаас үзэхэд 3,147.0 сая төгрөгийн эрдэм шинжилгээ төслийн санхүүжилт сургуулийн дансаар дамжаагүй төсөл хэрэгжүүлэгчийн дансаар хэрэгжсэн зэргийг дараагийн аудитаар нэмэлтээр горим сорил гүйцэтгэж шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Төв сургуулийн 11 талбар газрын бодит үнэ цэнийг 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдөр хийсэн үнэлгээний тайлангаар 118,930.1 сая төгрөгөөр үнэлсэн бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хийсэн үнэлгээний тайлангаар энэхүү 11 талбар газрын бодит үнэ цэнэ 99,992.5 сая төгрөгөөр буурч 18,937.6 сая төгрөгөөр үнэлэгдсэн байна. Дараагийн аудитаар газрын үнэлгээ огцом буурсан асуудлыг авч үзэх нь зүйтэй.

### **2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 006 тогтоолоор 2018 оны орлого, зардлын төсвийн төлөвлөгөөг хэлэлцэж баталсан байна.

Орлогын гүйцэтгэл: 2018 онд 36,162.5 сая төгрөгөөр төлөвлөж 37,357.9 сая төгрөгийн орлоготой ажиллаж төлөвлөгөөг 3.3 хувиар буюу 1,195.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Зардлын гүйцэтгэл: 2018 онд 31,937.2 сая төгрөгийн зардал төлөвлөн, 35,055.3 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөгөөг 9.8 хувь буюу 3,118.1 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 19 төрлийн 145 мэдээллийг байршуулснаас, 89 мэдээллийг хугацаанд нь, 55 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасны дагуу таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний 203 гүйлгээг байршуулснаас 162 удаагийн гүйлгээний бараа, ажил үйлчилгээний нийлүүлэгчийн хаягийг бичээгүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 342 удаагийн гүйлгээний мэдээллийг бүрэн байршуулсан. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлд 24 удаагийн тендер зарласнаас, 6 удаагийн тендерийн шалгараагүй оролцогчийн товч мэдээлэл, шалгараагүй үндэслэл шалтгааны мэдээллийг оруулаагүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг 95 хувь биелүүлсэн байна. Үүнд:

1. БСШУСпортын сайдын 2017 оны А/01 дугаар тушаалыг хэрэгжүүлэх, сургуулийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны хязгаар, цалингийн сангийн хэмжээг жил бүр батлуулж мөрдөх гэсэн зөвлөмж өгсний дагуу захирлын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/58 дугаар тушаалаар цалингийн сүлжээ, шатлал, цалингийн санд өөрчлөлт оруулсан байна.
2. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж хэвших, шилэн дансны хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах гэсэн зөвлөмжийн дагуу мэдээллийг байршуулахдаа хугацаа хоцроох, зарим гүйлгээний мэдээллийг иж бүрэн оруулаагүй байна.
3. Үндсэн ажилтантай хөдөлмөрийн гэрээнээс бусад гэрээ байгуулахгүй байх, гүйцэтгэсэн ажлын цалин хөлсийг харъяалагдах сургуулийн санхүүгээс олгож, дотоод хяналтыг сайжруулах гэсэн зөвлөмжийн дагуу захирлын 2018 оны 05 дүгээр сарын 15-ний өдрийн А/77 дугаар тушаалаар Аудитын

зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Анхан шатны баримттай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь бэлэн мөнгөний бүртгэл хөтөлдөггүй, цалингийн баримтанд цалин хөлсний тооцоололтой холбогдолтой шийдвэр баримтуудыг хавсаргадаггүй, эд хариуцагчид анхан шатны баримтыг бүрдүүлж, хөрөнгийн хөдлөлийн тайлан гаргаж хянуулдаггүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаал, 2018 оны 100 тоот тушаалуудын заалтуудыг тус тус зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, ажил гүйлгээ данс бүртгэлд тусгагдаагүй байх, холбогдох стандарт, хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг биелүүлж ажиллана.

**3.2 Авлага, өр төлбөр данстай холбоотой асуудал**

3.2.1 Илрүүлэлт

Тайлант оны эцэст авлага 4,439.7 сая төгрөг, өр төлбөр 6,005.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба өмнөх оноос авлага 1,210.5 сая төгрөг, өр төлбөр 268.1 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Жилийн эцсээрх авлага 47.8 сая төгрөг, өр төлбөр 97.9 сая төгрөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчиж байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд авлага, өр төлбөр буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй байна.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг биелүүлж ажиллана.

**3.3 Төсөл эрдэм шинжилгээний зардлын данстай холбоотой асуудал**

3.3.1 Илрүүлэлт:

Тайлант онд Төв сургууль 318.8 сая төгрөгийг, НЭМС 356.7 сая төгрөгийн зардлыг дэмжих анхан шатны баримтгүйгээр төсөл эрдэм шинжилгээний зардлаар бүртгэсэн. Төсөл хэрэгжүүлэгчид тайлан гаргаж журамлагдаагүй, төслийн гэрээнүүдийг монгол хэлээр бэлтгээгүй. НЭМС 494.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээний зардлыг төслийн орлого дансны дебет талд бүртгэж орлого бууруулах бичилт хийсэн зэрэг нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т "... бүрэн

аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 6 дугаар зүйлийн 6.3.1-т "төсвийн орлого, зарлага, хөрөнгө өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийлгүйгээр нийт дүнгээр төлөвлөж тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно". 7 дугаар зүйлийн 7.1-т "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь нягтлан бодох бүртгэлээ монгол хэлээр хөтөлнө" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

### 3.3.2 Эрсдэл:

Батлагдсан төсвөөс гадуур зардал гаргах, зориулалт бусаар зарцуулах, баримтгүй орлого, зарлага хүлээн зөвшөөрөх

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг биелүүлж ажиллана.

## **3.4 Бараа материал данстай холбоотой асуудал**

### 3.4.1 Илрүүлэлт:

Тайлант онд эм боох материал 239.1 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл 13.7 сая төгрөг, шатах тослох материал 39.6 сая төгрөг, нийт 292.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулалтын тайлан гаргаагүй зардлын дансанд бичсэн. 2.9 сая төгрөгийн 258 толгой малын нас дэвшилт, сүргийн бүртгэл хөтлөөгүй, тооллого хийж, тооцоог актаар баталгаажуулаагүй, малын дансны үнийг УСНББОУС 27-ийн дагуу бодит үнэ цэнээр бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

### 3.4.2 Эрсдэл:

Бараа материал санхүүгийн тайланд тусгагдаагүй байх, өөрийн эзэмшилд байхгүй байх, бараа материалтай холбоотой дансны бичилт буруу хийсэн байх, тооллого, тооцоог хийгээгүй байх

### 3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаал, 2018 оны 100 тоот тушаал, УСНББОУС 27-г мөрдөж ажиллах

#### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг биелүүлж ажиллана.

### **3.5 Зардлын данстай холбоотой асуудал**

#### 3.5.1 Илрүүлэлт:

Тайлант онд албан томилолтын удирдамж, гүйцэтгэсэн ажлын тайлан бичиж дүгнүүлэхгүйгээр гадаад томилолтын зардал 38.6 сая төгрөг, батлагдсан төсөв шийдвэргүйгээр Төв сургуулийн урсгал засварын зардалд 53.9 сая төгрөгийг зарцуулжээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасныг зөрчсөн байна.

#### 3.5.2 Эрсдэл:

Батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлэх, батлагдсан төсөвгүй зардал гаргах эрсдэлтэй байна.

#### 3.5.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, анхан шатны баримтыг бүрдлийг хангаж ажиллах

#### 3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг биелүүлж ажиллана.

### **3.6 Худалдан авалттай холбоотой асуудал**

#### 3.6.1 Илрүүлэлт:

Төв сургууль 12.0 сая төгрөгийн үнэтэй ноосон хөнжлийг худалдан авахдаа үнийн санал авч харьцуулалт хийгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйл, 33 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

#### 3.6.2 Эрсдэл:

Худалдан авах ажиллагаанд ил тод, тэгш өрсөлдөх боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулах эрсдэлтэй.

#### 3.6.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

### 3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг биелүүлж ажиллана.

## **3.7 Татвар, НДШ-ийн данстай холбоотой асуудал**

### 3.7.1 Илрүүлэлт:

ТЭШ-ний гэрээгээр ажиллагсдын 83.2 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 18.8 сая төгрөгийн нийгмийн даатгал шимтгэл суутгаагүй байна.

### 3.7.2 Эрсдэл:

НДШ-ийн хяналт шалгалтаар акт, алданги тооцогдох, төлөвлөгдөөгүй зардал гарах эрсдэлтэй.

### 3.7.3 Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

### 3.7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг биелүүлж ажиллана.

## **3.8 Тендер шалгаруулалттай холбоотой асуудал**

### 3.8.1 Илрүүлэлт:

Тайлант онд 1200 оюутны дотуур байр барих тендерийг шалгаруулахдаа 1-16 давхар барилга барих тусгай зөвшөөрөлгүй компанийг сонгон шалгаруулсан байна. Энэ нь Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.8-д “Хуулийн этгээд хуульд заасан зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үйл ажиллагааг эрхлэх эрх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс үүснэ”, 26.9-д “Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадварыг гагцхүү хуульд заасан үндэслэл, журмаар хязгаарлана”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлд заасныг тус тус зөрчсөн байна.

### 3.8.2 Эрсдэл:

Барилга угсралтын ажлын хүрээнд хариуцлага хүлээх эрх зүйн чадваргүй байх.

### 3.8.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалтыг мөрдөж ажиллах.

### 3.8.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг биелүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэгтгэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,295,039,066.72</b>	<b>34,024,205,769.31</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>26,247,608,863.16</b>	<b>28,590,532,029.88</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>10,579,952,180.41</b>	<b>15,399,237,462.55</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>9,049,630,744.90</b>	<b>13,831,057,917.77</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	9,049,630,744.90	13,831,057,917.77
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	<b>1,530,321,435.51</b>	<b>1,568,179,544.78</b>
31223	Арилжааны банк дахь харилцах	1,530,321,435.51	1,568,179,544.78
31500	Хадгаламж	15,667,656,682.75	13,191,294,567.33
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,229,229,043.27</b>	<b>4,439,719,584.43</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,946,281.74	4,365,644.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,175,559,652.36	1,199,805,083.80
33300	Татаас, санхүүжилтийн авлага		1,527,639,664.77
33400	Зээлийн хүүгийн авлага		1,485,542,640.05
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>1,823,528,459.17</b>	<b>222,366,551.81</b>
3351	Байгууллагаас авах авлага	1,814,904,438.17	196,011,783.16
3352	Хувь хүмүүсээс авах авлага	8,624,021.00	26,354,768.65
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>228,194,650.00</b>	<b>0.00</b>
<b>3361</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>228,194,650.00</b>	<b>0.00</b>
33613	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	228,194,650.00	
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>3,381,000.00</b>	<b>301,598,164.00</b>
